



**“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2022 он

“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтыг дунд хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг болох “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг баталсан.

Тус баримт бичгийн хүрээнд үндэсний нэгдмэл үнэт зүйл, хүний хөгжил, амьдралын чанар ба дундаж давхарга, эдийн засаг, засаглал, ногоон хөгжил, амар тайван аюулгүй нийгэм, бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн үндсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилт дэвшүүлсэн бөгөөд зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлсон.

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

1.1 Зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь арга хэмжээ тус бүрийн батлагдсан шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинд хүрсэн явцыг тодорхойлон, хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхэд үнэлгээ дүгнэлт өгөхөд чиглэгдэх бөгөөд 2021 оны явцын тайлангийн хувьд баримт бичгийн хэрэгжилтийн явцад үнэлэлт дүгнэлт өгөх, шаардлагатай санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшинд мэдээлэл өгөхөд оршино.

1.2 Арга зүй

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2021 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2-ын дагуу үндсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилтын хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний арга хэмжээний төлөвлөгөө 2021 онд батлагдаагүй, он тус бүрээр зорилтот түвшинг тодорхойлсон шалгуур үзүүлэлт байхгүй тул арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэгч байгууллага тус бүрээс томъёолон ирүүлсний дагуу хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн болно.

Улсын Их Хурлын харьяа (УИХ-д ажлаа тайлагнадаг буюу Засгийн газрын харьяаны бус) байгууллагуудын ирүүлсэн тайланг үнэлгээнд оруулаагүй бөгөөд хэрэгжилтийн тайлан ирүүлээгүй Шүүхийн ерөнхий зөвлөлийн хариуцах 1, Хүний эрхийн үндэсний комиссын хариуцах 2, Төрийн албаны зөвлөлийн хариуцах 3 арга хэмжээ, тайлан ирүүлсэн Авлигатай тэмцэх газрын хариуцах 2 арга хэмжээ буюу нийт 8 арга хэмжээний хэрэгжилтэд үнэлгээ хийгээгүй. Нийт үнэлгээний дунджийг тооцоолохдоо энэхүү 8 арга хэмжээг үнэлгээнээс хасаж тооцсон болно.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2021 оны хэрэгжилтэд хамаарах 47 зорилтын хүрээнд 243 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр баталснаас 235 арга хэмжээний тайлан (хавсралт 1.)-д хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Мөн тус баримт бичгийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-г

95 шалгуур үзүүлэлттэйгээр баталснаас (хавсралт 2.) 94 шалгуур үзүүлэлтийг хариуцагч байгууллагуудаас ирүүлсэн.

1. *Монгол Улсын Их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтын хүрээнд:*

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.2-т заасан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” баримт бичиг нь 9 зорилго, 47 зорилтын хүрээнд 2021-2030 онд нийт 965 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр баталснаас 2021 оны явцын дундаж үнэлгээ 50.2 хувийн биелэлттэй гарсан бол Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 9 зорилго, 47 зорилтын хүрээнд 2021-2025 онд 243 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, 2021 оны явцын дундаж үнэлгээ 79.3 хувийн биелэлттэй гарсан. /хавсралт 1/

Зорилго тус бүрээр хэрэгжилтийг хувиар илэрхийлэн гаргавал:



2021 оны хувьд “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын I үе шатны болон Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилтын тухайн таван жилд хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшинг он тус бүрээр тодорхойлоогүй тул Монгол Улсын Их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.3.3 дахь заалтын дагуу хүрэх дүнг тооцох боломжгүй байна.

2. *Монгол Улсын Их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.4 дэх заалтын хүрээнд:*

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.1-д заасан “хөгжлийн бодлогын зорилго, зорилтын тухайн таван жилд хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшинг

тодорхойлсон байх” гэсэн заалт хэрэгжээгүй, нарийвчилсан төлөвлөгөө байхгүй, тайлан ирүүлэхдээ 2021 оны хэрэгжилтээр зорилтот түвшинг тодорхойлсон, зорилт, арга хэмжээний биелэлтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2 буюу “зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлох аргачлал”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлсэн тул Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь өөрийн зорилтот түвшинд хүрсэн эсэхийг тодорхойлох боломжгүй, 2021 оны хэрэгжилтийн явцыг тооцон гаргасан болно. (хавсралт 3.)

Баримт бичгийн зорилт, арга хэмжээний үнэлгээний дүнг Хавсралт 4 болон 5, баримт бичгийн арга хэмжээний хэрэгжилтийн хувь /үнэлгээ/-ийг Хавсралт 6-д яам, байгууллагуудаар тус тусад нь гаргасан болно.

2.1 Үндэсний нэгдмэл үнэт зүйл

Үндэсний нэгдмэл үнэт зүйл буюу *“Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ”* гэсэн 1 дүгээр зорилгын хүрээнд үндэсний бахархал, эв нэгдэл, нүүдлийн соёл иргэншилт монгол, монгол хэл бичиг, эрдэм судлал, нийгмийн соёл гэгээрэл, дэлхийн монгол гэсэн 5 чиглэлийг суурь болгон 5 зорилтыг дэвшүүлэн тавьж, 16 арга хэмжээг баталсан.

Дээрх 5 зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх 16 арга хэмжээний явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 16 арга хэмжээний биелэлтийг ирүүлж, хэрэгжилт дунджаар 79.4 хувийн явцтай, тодорхой үр дүнд хүрсэн ангилалд багтаж байна.

Зорилт тус бүрээр явцыг харахад, үндэсний бахархал, эв нэгдлийн хүрээнд хэрэгжүүлэхээр 5 арга хэмжээг баталснаас 5 арга хэмжээний хэрэгжилтийг ирүүлж, дунджаар 86.0 хувийн явцтай, нүүдлийн соёл иргэншилт монгол хүрээнд арга хэмжээний хэрэгжилтийн явц 90.0 хувь, монгол хэл, бичиг 97.5 хувь, эрдэм судлал-нийгмийн соён гэгээрэл 80.0 хувь, дэлхийн монгол 43.3 хувийн явцтай байна.

Энэ хүрээнд Соёлын яамны 5 арга хэмжээ болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хэрэгжүүлсэн үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох, Боловсрол, шинжлэх ухааны яамны бүх шатны сургалтын байгууллагад Монгол хэл, бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлж, хүн бүрийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх зэрэг арга хэмжээнүүд үр дүнтэй хэрэгжиж байна.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн 5 зорилтоос 4 зорилт тодорхой үр дүнд хүрсэн бол “Олон улс дахь Монгол үндэсний үнэт зүйлсийн дархлааг бэхжүүлж, монгол соёлын хүрээг тэлнэ” гэсэн 1.5 дахь зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай буюу шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

2.2 Хүний хөгжил

Хүний хөгжлийн асуудлыг *“Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ”* гэсэн 2-р зорилгын хүрээнд боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, шинжлэх ухаан, инновац, хүнд ээлтэй амьдрах орчин, хөдөлмөрийн зах зээл, монгол хүний удмын сан гэсэн 7 чиглэлийг суурь болгон 7 зорилтыг дэвшүүлэн, 49 арга хэмжээг тодорхойлсон.

Дээрх 7 зорилтын хүрээнд баримт бичгийн 49 арга хэмжээний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 74.1 хувийн явцтай, тодорхой үр дүнд хүрсэн байна.

Зорилт тус бүрээр явцыг дурдахад боловсролын салбарт хэрэгжүүлсэн арга хэмжээний явц 87.5 хувь, эрүүл мэндийн салбар 80.0 хувь, гэр бүлийн чиглэлээр 62.0 хувь, шинжлэх ухаан, инновац 95.5 хувь, хүнд ээлтэй амьдрах орчны чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний явц 83.3 хувь, хөдөлмөрийн зах зээлийн чиглэлээр 58.0 хувь, монгол хүний удмын сангийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ 52.5 хувийн явцтай байна. Үүнээс 4 зорилтын хэрэгжилт тодорхой үр дүнд хүрсэн буюу хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа бол гэр бүл, хөдөлмөрийн зах зээл, монгол хүний удмын сан гэсэн 3 зорилтын удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Арга хэмжээний хэрэгжилтээс гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалах, хяналт тавих тогтолцоог бэхжүүлэх, оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг нэмэгдүүлэх, боловсролын удирдлагын мэдээллийн системийг бүх түвшинд хөгжүүлж, бусад салбарын мэдээллийн сантай холбон, бодлого, төлөвлөлт, статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээнд ашиглан, боловсролын үйлчилгээг цахимжуулах болон агаар, ус, хөрсний бохирдол болон дуу чимээг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлэх зэрэг 20 чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ 2021 онд үр дүнтэй сайн хэрэгжиж байна.

2.3. Амьдралын чанар ба дундаж давхарга

Монгол хүний амьдралын чанар ба дундаж давхаргын асуудлыг “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэсэн 3 дугаар зорилгын хүрээнд нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл, орлогод нийцсэн орон байр, хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес, дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, газрын харилцааны асуудлыг хамруулан 6 зорилт дэвшүүлэн тавьсан. Батлагдсан 27 арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд гүйцэтгэлээр 27 арга хэмжээний тайланг ирүүлсэн ба дунджаар 81.1 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн үнэлгээтэй гарлаа.

Зорилт тус бүрээр хэрэгжилтийн хувийг тооцон гаргахад, нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэлийн хүрээний хэрэгжилт 60.0 хувь, идэвхтэй амьдралын хэв маяг хүрээн дэх хэрэгжилт 61 хувь буюу эрчимжүүлэх шаардлагатай ангилалд, орлогод нийцсэн орон байр гэсэн чиглэлийн хэрэгжилт 85 хувь, хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнесийн чиглэлээр 83.0 хувь, эрүүл, газрын харилцааны чиглэлээр 97.5 хувийн явцтай буюу тодорхой үр дүнд хүрсэн, харин дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт чиглэлийн хэрэгжилт 100.0 хувь буюу үр дүнтэй хэрэгжсэн байна.

Зорилгын хүрээнд өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бий болгох, газрын харилцаа, хот байгуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтоох, газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг нь эхлүүлэх зэрэг ажлууд үр дүнтэй хэрэгжиж байна.

2.4. Эдийн засаг

“Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно” гэсэн 4 дүгээр зорилгын хүрээнд чинээлэг монгол, эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд, ухаалаг санхүүгийн зээл, бүс нутгийн хамтын

ажиллагаа, өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн, үндэсний баялгийн сан гэсэн 6 зорилтыг тодорхойлсон.

Зорилгын хүрээнд хэрэгжүүлэх 35 арга хэмжээний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дундаж үнэлгээ 68.8 хувийн явцтай, эрчимжүүлэх шаардлагатай үнэлэгдсэн. Зорилт тус бүрээр явцыг дурдахад:

- чинээлэг монгол 88.6 хувь,
- эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд 51.3 хувь,
- ухаалаг санхүүгийн зээл 97 хувь,
- бүс нутгийн хамтын ажиллагаа 71.3 хувь,
- өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн 40.0 хувь,
- үндэсний баялгийн сан 65 хувийн хэрэгжилттэй байна.

Тус зорилгын хүрээнд арга хэмжээний үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангасан, тогтвортой, өөрийгөө зохицуулах чадвар бүхий системийг бүрдүүлэх, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх болон цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах зэрэг 8 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

2.5. Засаглал

Бодлогын баримт бичгийн 5 дугаар зорилгын хүрээнд засаглалын асуудлыг дэвшүүлэн тавьж, *“Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.”* зорилгын дор ухаалаг засаглал, ухаалаг бүтэц, цахим монгол, чадварлаг, ёс зүйтэй төрийн алба, хүний эрхийг дээдлэсэн нийгэм, авилгагүй засаглал гэсэн 6 зорилтыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээг баталсан.

Зорилгод хамаарах 25 арга хэмжээний явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 17 арга хэмжээний биелэлтийг ирүүлснээс хэрэгжилт дунджаар 83.9 хувийн явцтай, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зорилт тус бүрээр явцыг авч үзвэл, ухаалаг засаглалын хүрээнд хэрэгжүүлэхээр 4 арга хэмжээг баталснаас 4 арга хэмжээний хэрэгжилтийг ирүүлж, дунджаар 62.5 хувийн явцтай, ухаалаг бүтэц хүрээнд үйл ажиллагааны явц 83.3 хувь, цахим монгол 100.0 хувь, чадварлаг ёс зүйтэй төрийн алба 97.5 хувь, хүний эрхийг дээдлэсэн нийгэм 90 хувь, авилгагүй засаглал 70 хувийн явцтай байна.

Цахим монгол зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй 4 арга хэмжээ болон ухаалаг бүтцийн хүрээний төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах шинэчлэл хийж эхлүүлэх, гадаад хөрөнгө оруулалт, худалдааг дэмжсэн төрийн зохицуулалтыг боловсронгуй болгож, нэг цонхны нэгдмэл бодлого хэрэгжүүлж хэвшүүлэх, төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчныг бүрдүүлэх зэрэг 9 арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж байна.

2.6. Ногоон хөгжил

Ногоон хөгжлийн асуудлаар *“Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан*

зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана” гэсэн 6 дугаар зорилгын хүрээнд эх байгаль анхдагч экосистем, байгалийн баялгийн үр өгөөж, үнэт баялаг ус, нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил гэсэн 4 зорилтыг тодорхойлж, авч хэрэгжүүлэх 18 арга хэмжээг багтаан баталсан.

Энэхүү зорилгын хүрээнд батлагдсан 18 арга хэмжээний 2021 оны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд гүйцэтгэлээр 18 арга хэмжээний тайланг ирүүлсэн ба дунджаар 78.6 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн үнэлгээтэй гарлаа.

Зорилт тус бүрээр хэрэгжилтийн хувийг тооцон үзэхэд:

-эх байгаль анхдагч экосистемийн хүрээний хэрэгжилт 85.0 хувь,

-байгалийн баялгийн үр өгөөж 97.0 хувь,

-үнэт баялаг ус хүрээнд 67.5 хувь,

-нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил чиглэлээр 65.0 хувийн явцтай байна.

Зорилгын хүрээн дэх нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил буюу 6.4 зорилтын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах, ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулах арга хэмжээнүүд болон нийт газар нутгийн 23 хувьд гидрогеологийн дунд масштабын зураглал хийж, усны нөөц баялгийн мэдээллийн бааз суурийг өргөжүүлж, төлөвлөлт, менежмент хийх боломж бүрдүүлэх зэрэг арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, үр дүнгүй байна.

2.7. Амар тайван аюулгүй нийгэм

Зэвсэгт хүчин, дархан хил, хүн, нийгмийн амар тайван байдал, хууль сахиулах салбарын хөгжил, мэдээллийн аюулгүй байдал гэсэн 5 зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд “Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана” гэсэн зорилгыг дэвшүүлэн тавьж, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлсон.

Дээрх 5 зорилтын хүрээнд баримт бичгийн 23 арга хэмжээний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 23 арга хэмжээний биелэлтийг ирүүлсэн байна. Зорилгын хүрээнд хэрэгжилт дунджаар 91.1 хувийн явцтай, тодорхой үр дүнд хүрсэн буюу хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн байна.

Зорилт тус бүрээр явцыг дурдахад зэвсэгт хүчний чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ 97.5 хувь, дархан хилийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ 90.0 хувь, хүн нийгмийн амар тайван байдал 72.5 хувь, хууль сахиулах салбарын хөгжил 95.7 хувь, мэдээллийн аюулгүй байдал чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ 100.0 хувийн хэрэгжилт байна.

Тус зорилгын хүрээнд авсан арга хэмжээний 16 нь үр дүнтэй хэрэгжиж, 5 арга хэмжээ нь тодорхой үр дүнд хүрсэн бөгөөд 1 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна. Харин үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан хүнсний агуулах, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулах ажлын үр дүнгийн хэрэгжилт төсөв, хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй, үр дүн муутай хэрэгжсэн байна.

2.8. Бүс, орон нутгийн хөгжил

“Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ” гэсэн 8 дугаар зорилгын хүрээнд дэд бүтэц, аялал жуулчлал, тогтвортой хөдөө аж ахуй гэсэн 3 үндсэн зорилт дэвшүүлэн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон.

Дээрх 3 зорилтын хүрээнд баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 29 арга хэмжээний биелэлтийг ирүүлж, хэрэгжилт дунджаар 75.5 хувийн явцтай, тодорхой үр дүнд хүрсэн үзүүлэлттэй байна.

Зорилт тус бүрээр явцыг харахад аялал жуулчлалын хүрээнд арга хэмжээний явц 90.0 хувьтай байгаа бол дэд бүтцийн чиглэлээр явц 69.7 хувь, тогтвортой хөдөө аж ахуй чиглэлээр хэрэгжилт 66.7 хувийн явцтай, арга хэмжээг сайжруулах шаардлагатайгаар үнэлэгдэж байна.

8 дугаар зорилгын хүрээнд малын гаралтай түүхий эд боловсруулах, экспортлох үйлдвэр, технологийн парк байгуулж, ажлын байрыг шинээр бий болгож, малчдын орлогыг өсгөх, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг дээшлүүлэх зорилгоор хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэн экспортлох чиглэлийн боловсруулах үйлдвэрүүдийг богино хугацаанд барьж ашиглалтад оруулах гэсэн 2 арга хэмжээ шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, үр дүнгүй үнэлэгдлээ.

2.9. Улаанбаатар ба дагуул хот

“Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ” гэсэн 9 дэх зорилгын хүрээнд хүн төвтэй хот, орчин төвтэй шийдэл, төлөвлөлт төвтэй хөгжил, хотын сайн засаглал, дагуул хот гэсэн 5 зорилт дэвшүүлж, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон.

Баримт бичгийн батлагдсан 21 арга хэмжээний 2021 оны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд гүйцэтгэлээр 21 арга хэмжээний тайланг ирүүлсэн ба дунджаар 81.2 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн үнэлгээтэй гарлаа.

Зорилт тус бүрээр хэрэгжилтийн хувийг тооцон гаргахад,
-хүн төвтэй хотын хүрээнд хэрэгжилт 73.3 хувь,
-орчин төвтэй шийдлийн хүрээнд 88.8 хувь,
-төлөвлөлт төвтэй хөгжлийн хүрээнд хэрэгжилт 85.0 хувь,
-хотын сайн засаглалын хүрээнд 90.0 хувь,
-дагуул хотын хүрээнд хэрэгжилт 68.9 хувь байна.

Зорилтыг журмын 6.2.3-ийн дагуу 4 зорилт тодорхой үр дүнд хүрсэн, 1 зорилт эрчимжүүлэх шаардлагатай үнэлгээтэй гарсан байна.

Улаанбаатар ба дагуул хотын хүрээнд хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг дэмжих тогтолцоотой болгох, Нийслэл эдийн засгийн хувьд бие даан хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлэх 2 арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй 100 хувийн хэрэгжилттэй буюу зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүнтэй үнэлэгдсэн байна.

Гурав. Шалгуур үзүүлэлт

УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 95 шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг 2025 оноор тодорхойлж, шалгуур үзүүлэлтийн мэдээллийг 2025 онд нэг удаа гаргахаар баталсан.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 1-р хавсралтад зааснаар жил бүрийн 2 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 1-ний хооронд тайланг нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлэхээр заасан бөгөөд 2021 оны шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг мэдээлэл гарах боломжтой хувилбараар хэрэгжүүлэгч байгууллагуудаас ирүүлснээр 94 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин, хэрэгжилтийг ирүүлсэн болно.

УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-ий 15 болон 18 дугаарт байгаа “Бүлэг дүүргэлт (боловсролын бүх түвшнээр)” шалгуур үзүүлэлтүүд техникийн алдааны улмаас давхцаж байгааг анхаарах нь зүйтэй байна.

2021 оны байдлаар үндэсний нэгдмэл үнэт зүйлсийн хүрээнд батлагдсан шалгуур үзүүлэлтээс шинэ бүтээл, патентын мэдүүлгийн тухайд Оюуны өмчийн газрын Аж үйлдвэрийн өмчийн мэдээллийн санд 2021 онд шинэ бүтээлийн 4942, ашигтай загвар 3307, Бүтээгдэхүүний загвар 3074, Барааны тэмдэг 79279, Газар зүйн заалт 34 тус тус бүртгэгдсэн мэдээллийг ирүүлсэн. Номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь зорилтот түвшиндээ хүрээгүй боловч суурь түвшнээс 0.01 хувиар өссөн байна. Цахим сан хөмрөгт ном хөрвүүлэх ажил техник, технологийн нөөц боломжгүйгээс ахиц багатай байна.

1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудлын тоо гэсэн шалгуур үзүүлэлтийн тухайд тайлант хугацаанд зорилтот түвшнээс (+5.6) илүү нэмэгдэж, 2020 оны эцсийн байдлаар соёл, урлагийн байгууллагын нийт суудлын тоо 124,531 болсон байна. Монгол Улсын жилийн дундаж хүн амын тоо 3,225,152 байна. Суудлын нийт тоог хүн амын тоонд харьцуулан 1,000 хүнд ногдохоор тооцсон үзүүлэлт 38.6 байна.

Хүний хөгжлийн үзүүлэлт зорилтот түвшнээс 0.77-оос 0.774 болж өссөн байна. Мөн 2021 оны байдлаар Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг жендэрийн зөрүүтэй байдлын үзүүлэлтээр /gender global index report/ дэлхийн улс орнууд жендэрийн тэгш байдлыг хангахад дунджаар 67.7% байна.

Монгол улсын хувьд 2020 онд дэлхийн 156 орноос 79-р байранд байсан бол 2021 онд 69-р байранд, бүсийн хэмжээнд 7-р байранд орсон ахиц дэвшилттэй харагдаж байна. Энэхүү индексийг 4 шалгуурын хүрээнд гаргадаг бөгөөд үүнд:

1. Эдийн засгийн оролцоо ба боломжоор 2020 онд 29-т байсан бол 2021 онд 23-т
2. Боловсрол эзэмшилтээр 2020 онд 71-т байсан бол 73-т
3. Эрүүл мэнд ба амьд гарах боломжоор 2020 онд 1-т, 2021 онд мөн адил байр,
4. Улс төр эрх мэдлийн хүрээнд 2020 онд 120-т байсан бол 2021 онд 116-т орсон үзүүлэлттэйгээр тус тус ахиц дэвшилттэй үзүүлэлтүүд гарчээ.

Иймд Монгол улсын Жендэрийн тэгш бус байдлын үзүүлэлт дэлхийн үзүүлэлтэд байр ахисан дэвшилттэйгээр ажиллаж байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ын нийгмийн даатгалд хамрагдсан хувь 86.6 байна. Энэхүү тооцооллын хүрээнд ажиллах хүчний тоо 2021 оны 3 дугаар улирлын байдлаар 1,226,792.0, нийт даатгуулагчийн тоо 2021 оны 3 дугаар улирлын байдлаар 1,062,030.0 байна. Ажиллах хүчний тооны албан ёсны статистик үзүүлэлт 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар гараагүй байна.

Шалгуур үзүүлэлтийн 48 дугаарт байгаа “Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар)”-д хамаарах арга хэмжээний хувьд, “Ковид-19” цар тахлын улмаас улс орон даяар “Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал”, “Бүх нийтийн бэлэн байдал” зарлаж, нийтийг хамарсан арга хэмжээг тодорхой хугацаагаар хориглосон, мөн хорио цээрийн дэглэмийг мөрдөх шаардлагын улмаас сорилд хамруулах боломжгүй болсон тул 2021 онд иргэдээс бие бялдрын түвшин тогтоох сорил аваагүй болно.

Дэлхийн зах зээл дээрх уул, уурхайн эрдэс бүтээгдэхүүний үнэ өсөж, эрэлт нэмэгдсэн хэдий ч КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр хилийн боомтууд дээр хүндрэл үүсэж, түүхий эдийн экспортын өсөлтийг огцом бууруулж, уул уурхайн салбарын өсөлтийн хурдцыг сааруулсан нь уул уурхайн салбарыг дагасан бусад салбарын өсөлтийг мөн бууруулсан байна.

Засгийн газраас 10 их наяд төгрөгийн цогц хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд дотоодын эдийн засагт сэргэлт ажиглагдаж байгаа бөгөөд 300 орчим мянган ажлын байр хадгалж, ажил эрхлэлт нэмэгдэж байгаа нь эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байгаа бөгөөд Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийг цаг алдалгүй шийдвэрлэж, “Алсын хараа–2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлснээр урт хугацаанд эдийн засгийн өсөлт дунджаар 6 хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого 2 дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүрснээр дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ өсөх хандлагатай байна.

Инфляцын өсөлт 2021 оны 2 дугаар улирлаас хойш идэвхжиж 2021 оны 11 дүгээр сарын гүйцэтгэлээр жилийн 10.5 хувь, оны эхнээс 11.1 хувь, сарын 1.3 хувийн өсөлттэй гарч, иргэдийн худалдан авах чадварт хүндрэл учруулж байна. Урьдчилсан тооцооллоор 2021 оны жилийн эцэст инфляц хоёр оронтой тоонд гарч өсөх тодорхой болж байгаа бол Монголбанкны төсөөллөөр 2022 оны сүүлийн хагаст зорилтот түвшин орчимд тогтворжино гэж үзэж байна.

2021 оны 11 дүгээр сарын байдлаар хэрэглээний бараа, үйлчилгээний жагсаалтад багтсан 373 бүтээгдэхүүн, үйлчилгээнээс 204 нь үнийн өсөлтөд өртжээ.

УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлснээр урт хугацаанд эдийн засгийн өсөлт дунджаар 6 хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого 2 дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүрч нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэнэ.

Хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны нийт махны хэрэглээнд эзлэх хувь 27.2 хувь болж буурсан байна. Үүний шалтгаан нь 2021 онд малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан хорио цээрийн дэглэм тогтоосноос үүдэн малын хөдөлгөөн, махны тээвэрлэлтийг хязгаарласан тул нийлүүлэлт буурсантай холбоотой. Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг системийн хэмжээнд авч үзэх шаардлага тулгарч байна.

ОХУ-ын “Роснефть” компаниас нийлүүлж буй Евро-5 стандартын шатахууны импорт нэмэгдэхгүй байна. Үнийн зөрүүг арилгах зорилгоор автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг экологийн бага ангиллын стандартын шатахуунаас тодорхой хувиар бага татварын орчин бүрдүүлэх шаардлага тулгарсан. Засгийн газраас Автобензин, дизель түлшний онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан тогтоох, Евро-5 стандартаас доош чанартай шатахууныг жижиглэнгээр худалдан борлуулахыг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох сайд нар болон Нийслэлийн Засаг даргад даалгаад байна.

КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр хилийн боомтууд дээр хүндрэл үүсэж түүхий эдийн экспортын өсөлтийг огцом бууруулж уул уурхайн салбарын өсөлтийн хурдцыг сааруулсан нь уул уурхайн салбарыг дагасан бусад салбарын өсөлтийг мөн бууруулсан учраас экспорт 9247.1 сая ам.доллар буюу зорилтот түвшний хуваарьт нийцэхгүй байна.

Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь Ойн судалгаа, хөгжлийн төвөөс гаргадаг ой зохион байгуулалтын ажлын тайлангаас харахад 8 хувьтай буюу өсөлтгүй байна.

“Шинээр байгуулагдах хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн паркийн тоо” шалгуур үзүүлэлтийн тухайд, 30 хувьтай буюу хангалтгүй хэмжээнд байна. “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөл” болон “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн хүрээнд тодорхойлсон бүлэг суурингийн тогтолцоотой уялдуулан 19 аймгийн 59 суманд “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоолоор баталсан. Энэхүү төслийн хүрээнд УТП-ын инженерийн дэд бүтцийг байгуулахаар төлөвлөж байна.

Шалгуур үзүүлэлтийн 91 дугаарт батлагдсан “Шинээр баригдах төмөр замын урт”-тай холбоотой мэдээллийг Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлснийг үзвэл, 2021 онд салбар зам 14.3 км баригдсан ба Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын гол замын 129 км, өртөө зөрлөгийн замын 13 км, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын гол зам 63 км буюу нийт 219.3 км төмөр замд техникийн комисс ажилласан дүнтэй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн мэдээллээс харахад, Улаанбаатар хотын агаар дахь PM 2.5 тоосонцор зорилтот түвшин болох 40-өөс 44, PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж 88-аас 89 болж ихэссэн байна. Улаанбаатар хотын агаарын чанарыг 2021 онд гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт хэмжилтийн автомат багажаар тодорхойлсон тоосонцорын жилийн дундаж агууламж, ЦУОШГ-ын мэдээлэл үүнд багтсан байна.

Дөрөв. Баримт бичгийн арга хэмжээний санхүүжилт

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 86 арга хэмжээнд хамаарах зарим үйл ажиллагааны санхүүжилт хийгдсэн бөгөөд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийн хувьд 76 нь улсын төсөв, 12 нь гадаад буцалтгүй зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжигдсэн байна. Бусад арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн ажлуудыг үйл ажиллагааны зардлаар санхүүжүүлсэн байна.

Хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийн зорилгын хүрээнд санхүүжилт хийгдсэн байдал (төгрөгөөр/ам-долларын ханшийг Монголбанкны 2021.12.31-ний өдрийн ханшаар тооцоолов/):

№	Зорилго, зорилт	Санхүүжүүлсэн арга хэмжээний тоо	Санхүүжилт /сая.төг/
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	10	13,261.9
2	Хүний хөгжил	10	57,520.5
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	15	365,318.7
4	Эдийн засаг	7	38,024.0
5	Засаглал	5	15,332.4
6	Ногоон хөгжил	8	7,527.3
7	Амар тайван аюулгүй нийгэм	3	3,386.3
8	Бүс, орон нутгийн хөгжил	13	270,551.2
9	Улаанбаатар ба дагуул хот	15	116,733.1
Нийт		86	887,654.4

Баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд нийт 887 тэрбум 654 сая 400 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Үүнээс Бүс, орон нутгийн хөгжлийн зорилгын зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээнд хамгийн их санхүүжилт буюу 270 тэрбум 551 сая 200 мянган төгрөг, Амар тайван, аюулгүй нийгэм зорилгын зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээнд хамгийн бага санхүүжилтийг буюу 3 тэрбум 386 сая 300 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тав. Дүгнэлт

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн 2021 оны явцын тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон 16 яамд, УИХ-ын харьяа байгууллага болох Үндэсний Статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Авлигатай тэмцэх газар, Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болох Жендэрийн үндэсний хороо, Биеийн тамир спортын улсын хороо, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Шадар сайдын харьяаны байгууллага болох Онцгой байдлын ерөнхий газар, Стандарт хэмжил зүйн газар “Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим зэрэг нийт 28 байгууллагаас ирүүлсэн болно.

Шадар сайдын ажлын алба өөрийн эрхлэх асуудлын хүрээний харьяа зарим байгууллага өөрийн байгууллагын зүгээс ирүүлэх шаардлагатай тайланг хугацаа хоцроосон тул үнэлгээнд оруулах боломжгүй юм.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2021 оны хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 9 зорилгын хүрээнд явц **79.3 хувийн биелэлттэй** үнэлэгдсэн байна.

Ангилал	Үнэлгээ	Үнэлгээ хийсэн арга хэмжээний тоо
Үр дүнгүй	0-30%	24
Эрчимжүүлэх шаардлагатай	31-69%	36
Тодорхой үр дүнд хүрсэн	70-99%	86
Үр дүнтэй	100%	89
Нийт дүн	79.3%	235

Үнэлгээг журмын 6.2.3-д заасан ангилалд шилжүүлэн тооцвол, 89 арга хэмжээ үр дүнтэй, 86 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, 36 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай, 24 арга хэмжээ үр дүнгүй үнэлэгдсэн.

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө 2021 онд амжиж батлагдаагүйгээс яам, агентлагуудаас шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг өөрсдөө томъёолон ирүүлсэн ба зорилт, арга хэмжээний биелэлт орхигдох, дутуу тайлагнах болон арга хэмжээг хэтэрхий өндрөөр буюу бодит бусаар үнэлэх, 2021 оны шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлохгүй ирүүлэх зэрэг асуудал гарч байгаа нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хүндрэл үүссэн болно.

Жишээ нь баримт бичгийн 2021 оны зорилтот (хүрэх) түвшинг яам, газрууд өөрсдөө тодорхойлж ирүүлснээс үүдэн Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн 6 арга хэмжээний 5 нь, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн 29 арга хэмжээний 18 нь, Сангийн яамны 21 арга хэмжээний 18 нь, Хууль зүй, дотоод хэргийн яамны 23 арга хэмжээний 14 нь, Батлан хамгаалах яамны 4 арга хэмжээний 3 нь, Барилга, хот

байгуулалтын яамны 28 арга хэмжээний 18 нь, Боловсрол, шинжлэх ухааны яамны 24 арга хэмжээний 17 нь биелэлтийн үнэлгээ 100 хувьтай гарлаа.

Цаашид УИХ-аас “Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай” хуульд 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар өөрчлөлт орсонтой холбогдуулж дээрх хуулийн 9.6.5-д төрийн захиргааны төв байгууллагуудын чиг үүрэгт “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх”-ийг хамааруулан заасан байна. Иймд Засгийн газрын яам, агентлагууд хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхээр эрхлэх асуудлын хүрээнд арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийн ханган ажиллах боломжтой юм.

Засгийн газрын яам, агентлагууд хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийн 2021 оны хэрэгжилт (явц)-ийг тайлагнахдаа дор дурдсан зарим нийтлэг алдаа, дутагдлыг гаргаж байгаад анхаарах хэрэгтэй байна.

-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 6.8-д заасан “Хэрэгжилтийн тайланг дээд шатны байгууллагад тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаана” гэсэн заалтыг баримтлаагүй, тайлангийн хэрэгжилтэд яам, газар, хэлтсийн үндсэн үйл ажиллагааны тайлангаас буюу бусад байгууллагатай харилцсан албан бичиг, мэдээ мэдээллийг оруулах,

-Мөн Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамд журмын 10.7.2-т заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг сайд/даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулан ирүүлээгүй,

-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу тайланг ирүүлэхдээ арга хэмжээний хүрсэн түвшин, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаагаагүй;

-Тайлангийн хүрсэн түвшин, үр дүнг оруулахдаа зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтот түвшинд хүрэхтэй холбоотой төлөвлөлт, боловсруулалтын болон шийдвэрлэгдсэн гол ажлыг оновчтой, товч тодорхой байдлаар тайлагнаагүй байна.

Цаашид, яам, газрууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах баримт бичгийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төсөл болон бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг төрийн захиргааны төв байгууллагаас жил бүрийн Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөлд тусгуулж батлуулан, баримт бичгийн зорилт, арга хэмжээний ангилал тус бүрт хамаарах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд гарсан хөрөнгийн хэмжээ (зардал), хэмжих нэгж (төгрөгөөр), санхүүжилтийн эх үүсвэрийг тогтмол, нэг загвар, аргачлалаар тайлагнаж хэвших шаардлагатай байна.

Зургаа. Цаашид авах арга хэмжээний санал

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтуудыг хангах ажлын хүрээнд хариуцсан яам, агентлагийн зүгээс олон талт арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгаа ч цаашид анхаарч ажиллах шаардлагатай нийтлэг асуудлууд байна. Үүнд:

1.Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.6.5-д заасны дагуу эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх”-ийг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт үүрэг болгох,

2. Мөн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээ, үйл ажиллагаа, тэдгээрийн тухайн оны хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх (зорилтот) түвшинг урьдчилан тодорхойлж, байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөлтөнд тусгаж, бусад төрийн захиргааны төв байгууллагын арга хэмжээтэй уялдуулан нийцүүлэх талаар Засгийн газрын яамд Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран ажиллах,

3. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг салбар хооронд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар ханган төрийн захиргааны төв байгууллагуудад бодлогын баримт бичгийн боловсруулалт, төлөвлөлт, тайлагналтад арга зүйн зөвлөгөө өгөхөд Эдийн засаг, хөгжлийн яам анхаарч ажиллах шаардлагатай байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Баримт бичгийн зорилт, арга хэмжээний үнэлгээний танилцуулгын хүснэгт

Зорилго, зорилт Үнэлгээний хувь			Бүгд	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	Хүний хөгжил	Амьдралын чанар ба дундаж давхарга	Эдийн засаг	Засаглал	Ногоон хөгжил	Амар тайван аюулгүй нийгэм	Бүс орон нутгийн хөгжил	Улаанбаатар ба дагуул хот
Батлагдсан	Зорилтын тоо		47	5	7	6	6	6	4	5	3	5
	Арга хэмжээний тоо		243	16	49	27	35	25	18	23	29	21
Тайлагнасан		Арга хэмжээний тоо	235	16	49	27	35	17	18	23	29	21
Үүнээс	100 хувь	Үр дүнтэй	89	7	20	10	8	9	9	16	8	2
	70-99 хүртэл хувь	Тодорхой үр дүнд хүрсэн	86	6	20	13	11	5	5	5	8	13
	31-69 хүртэл хувь	Эрчимжүүлэх шаардлагатай	36	0	5	2	8	3	0	1	11	6
	0-30 хүртэл хувь	Үр дүнгүй	24	3	4	2	8	0	4	1	2	0
Хэрэгжилтийн хувь			79.3%	79.4%	74.1%	81.1%	68.8%	83.9%	78.6%	91.1%	75.5%	81.2%

Баримт бичгийн зорилт, арга хэмжээний үнэлгээний танилцуулгын хүснэгт

№	Зорилго, зорилт		Батлагдсан	Тайлагнасан	Явцын дундаж /хувь/
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	Үндэсний бахархал эв нэгдэл	5	5	86
2		Нүүдлийн соёл иргэншилт монгол	4	4	90
3		Монгол хэл, бичиг	2	2	97.5
4		Эрдэм судлал-нийгмийн соён гэгээрэл	2	2	80
5		Дэлхийн монгол	3	3	43.3
Нийт			16	16	79.4
6	Хүний хөгжил	Боловсрол	12	12	87.5
7		Эрүүл мэнд	8	8	80
8		Гэр бүл	5	5	62
9		Шинжлэх ухаан, инновац	9	9	95.5
10		Хүнд ээлтэй амьдрах орчин	6	6	83.3
11		Хөдөлмөрийн зах зээл	5	5	58
12		Монгол хүний удмын сан	4	4	52.5
Нийт			49	49	74.1
13	Амьдралын чанар ба дундаж давхарга	Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл	5	5	60
14		Орлогд нийцсэн орон байр	4	4	85
15		Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес	5	5	83
16		Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт	2	2	100
17		Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг	5	5	61
18		Газрын харилцаа	6	6	97.5
Нийт			27	27	81.1
19	Эдийн засаг	Чинээлэг монгол	7	7	88.6
20		Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд	16	16	51.3
21		Ухаалаг санхүүгийн зээл	5	5	97

22		Бүс нутгийн хамтын ажиллагаа	4	4	71.3
23		Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн	2	2	40
24		Үндэсний баялгийн сан	1	1	65
Нийт			35	35	68.8
25	Засаглал	Ухаалаг засаглал	4	4	62.5
26		Ухаалаг бүтэц	3	3	83.3
27		Цахим монгол	4	4	100
28		Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба	7	4	97.5
29		Хүний эрхийг дээдлэсэн нийгэм	4	1	90
30		Авилгагүй засаглал	3	1	70
Нийт			25	17	83.9
31	Ногоон хөгжил	Эх байгаль анхдагч экосистем	2	2	85
32		Байгалийн баялгийн үр өгөөж	5	5	97
33		Үнэт баялаг ус	4	4	67.5
34		Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил	7	7	65
Нийт			18	18	78.6
35	Амар тайван аюулгүй нийгэм	Зэвсэгт хүчин	4	4	97.5
36		Дархан хил	4	4	90
37		Хүн, нийгмийн амар тайван байдал	6	6	72.5
38		Хууль сахиулах салбарын хөгжил	7	7	95.7
39		Мэдээллийн аюулгүй байдал	2	2	100
Нийт			23	23	91.1
40	Бүс, орон нутгийн хөгжил	Дэд бүтэц	11	11	69.7
41		Аялал жуулчлал	3	3	90
42		Тогтвортой хөдөө аж ахуй	15	15	66.7
Нийт			29	29	75.5
43	Улаанбаатар ба дагуул хот	Хүн төвтэй хот	3	3	73.3
44		Орчин төвтэй шийдэл	4	4	88.8
45		Төлөвлөлт төвтэй хөгжил	5	5	85
46		Хотын сайн засаглал	3	3	90
47		Дагуул хот	6	6	68.9
Нийт			21	21	81.2
БҮГД			243	235	79.3%